



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/93

Номгон

“Хүн амын махны хэрэгцээг 2024 оны хаврын
улиралд хангах төсөл сонгон шалгаруулах
ажлын хэсэг томилох тухай

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.5 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 344 дүгээр тогтоол "Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам"-ын 1.2, 2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/59 дүгээр тогтоол "Баянхонгор аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 175 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн амын 2024 оны хаврын улиралд шаардлагатай 180 тн махны нөөцийг бүрдүүлэх, махны хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй, үнийг тогтворжуулах зорилготой нөөцийн махны төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Т.Хишигбаатар

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

У.Балжинням

Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Анухатан

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газрын хэрэглэгчийн эрхийг хамгаалах улсын байцаагч

Г.Өлзийнаран

Мал эмнэлгийн газрын улсын байцаагч

Нарийн бичгийн дарга:

Б.Биндэръяа


Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Махны хангамжийг тогтвортой байлгах, нийлүүлэлтийн хомсдол, үнийн хөөрөгдөл бий болохоос урьдчилан сэргийлж, нутаг дэвсгэрийн хүн амыг махаар тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах, төслийг сонгон шалгаруулж, танилцуулахыг ажлын хэсэг (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

824019140

2.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН